

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 01 дүгээр сарын 16

№01

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн Эрдмийн зөвлөлийн 1-203 тоот танхимд 10:00 цагт эхлэв. Хурлыг ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдав.

Хуралд: Дарга Н.Эрдэнэхүү, нарийн бичгийн дарга М.Эрдэнэтуяа, гишүүн Д.Оюунцэцэг, М.Оюунчимэг, Л.Амартүвшин, Б.Батдэмбэрэл, А.Болормаа, Я.Батцэцэг, Ш.Цоож, Р.Мядагмаа, Г.Батцэцэг, Ч.Улам-Оргил, Д.Ариунболор, Д.Дулмаа, Г.Ариунтөгс нар оролцов.

Хуралд оролцоогүй: гишүүн Б.Оюунтунгалаг эрүүл мэндийн шалтгаантай чөлөөлөгдсөн.

Хэлэлцсэн асуудал:

1. ХЕХ-ны шинэчлэгдсэн бүрэлдэхүүн, 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улиралд ХЕХ-ноос зохион байгуулах гол ажлууд
Сургалт, цахим шилжилтийн газрын захирал
Н.Эрдэнэхүү
2. БШУ-ы Сайдын А/160 тушаалаар батлагдсан ШУТИС-д сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулах асуудал
Сургалт, цахим шилжилтийн газрын захирал
Н.Эрдэнэхүү
Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны
мэргэжилтэн Г.Ариунтөгс
3. Шинээр нээхээр төлөвлөн урьдчилсан магадлан итгэмжлэл хийгдсэн, БШУ-ы Сайдын А/160 тушаалд индексстэй сургалтын хөтөлбөрүүдийн асуудал
 - 3.1. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" бакалаврын сургалтын хөтөлбөр
ГУУС-ийн ЭБИС-ын эрхлэгч Г.Ганбилэг
 - 3.2. "Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл" бакалаврын сургалтын хөтөлбөр
ГУУС-ийн ГТӨС-ын эрхлэгч М.Оюунтөгс
 - 3.3. "Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын технологи" бакалаврын сургалтын хөтөлбөр
МехТС-ийн МҮС-ын дэд профессор Л.Тэлмэнбаяр
 - 3.4. "Хэрэглээний физик" бакалаврын сургалтын хөтөлбөр
ХШУС-ийн ФТ-ийн эрхлэгч Ч.Алдармаа
 - 3.5. "Статистик" (дотоод) бакалаврын сургалтын хөтөлбөр
ХШУС-ийн МТ-ийн эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгч
Ц.Балжинням
4. Шинээр нээхээр төлөвлөсөн, БШУ-ы Сайдын А/160 тушаалд индексстэй сургалтын хөтөлбөрүүдийн асуудал
 - 4.1. "Хот бүс нутгийн төлөвлөлт" магистрын сургалтын хөтөлбөр
БАС-ийн Архитектурын салбарын дэд профессор
Э.Пүрэв-Эрдэнэ
 - 4.2. "Худалдаа" бакалаврын сургалтын хөтөлбөр
БуХС-ийн ТМС-ын эрхлэгч Л.Амартүвшин
 - 4.3. "Орон судлал" сургалтын хөтөлбөрөөр Турк улсын Измир Катип Челеби их сургуультай хамтарсан (1+1,5) хөтөлбөр хэрэгжүүлэх
БуХС-ийн ХУС-ын ахлах багш Д.Очирпүрэв

- 4.4. "Бизнес шинжлэл, загварчлал" бакалаврын сургалтын хөтөлбөр
БуХС-ийн ТМС-ын ахлах багш М.Бурмаа
 - 4.5. "Бизнес шинжлэл, загварчлал" магистрын сургалтын хөтөлбөр
БАТС-ийн СЧА-ны дарга М.Банзрагч
 - 4.6. "Энтрепренершип ба инноваци" магистрын сургалтын хөтөлбөр
БАТС-ийн БУМС-ын ахлах багш Н.Мөнхөө
 - 4.7. "Инженер геологи, геотехник" бакалаврын сургалтын хөтөлбөр
БАТС-ийн СЧА-ны дарга М.Банзрагч
 - 4.8. "Хийн инженерчлэл" бакалаврын сургалтын хөтөлбөр
ГУУС-ийн ГТӨС-ын эрхлэгч М.Оюунтөгс
5. Шинээр нээхээр төлөвлөж байгаа А/160 тушаалд индексгүй сургалтын хөтөлбөрүүдийн асуудал
 6. Бусад асуудал
 - 6.1. Хөтөлбөрийн нэр өөрчлөх санал
"Хүнсний үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж" хөтөлбөрийн нэрийг "Хүнсний үйлдвэрлэлийн мехатроник инженер" болгож өөрчлөх.
ҮТС-ийн ХИС-ын ахлах багш Ж.Балжинням

Шийдвэрлэсэн нь:

| № | Хэлэлцүүлсэн асуудал | Санал, зөвлөмж | ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: |
|---|---|---|---|
| 1 | ХЕХ-ны шинэчлэгдсэн бүрэлдэхүүн, 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улиралд ХЕХ-ноос зохион байгуулах гол ажлууд | | БШУ-ы Сайдын А/160 тушаалаар батлагдсан хөтөлбөр /мэргэжлийн чиглэл/-ийн дагуу сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулахын тулд сургалтын хөтөлбөрт тавигдах шалгуур, шаардлагыг ХЕХ-ноос шинээр боловсруулах ХЕХ-ний ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх |
| 2 | ШУТИС-ийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл | | |
| 3 | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” бакалаврын сургалтын хөтөлбөр | Тухайн хөтөлбөр нь салбар дундын хөтөлбөр байх бөгөөд ОУ-ын чиг хандлагыг судлан, хавсарга хичээлүүдийг бусад салбараас нэмж тусгах | ХЕХ-ны гишүүдийн санал зөвлөмжийг тусгаж, сайжруулаад дахин хэлэлцүүлэхээр буцаалаа. (Шинжээч: Б.Оюунтунгалаг, Г.Батцэцэг) |
| 4 | “Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл” бакалаврын сургалтын хөтөлбөр | Хамтын ажиллагааны гэрээг шуурхай шийдвэрлэх | ХЕХ-ны томилогдсон гишүүний санал зөвлөмжийг тусган Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхээр дэмжлээ. УМИ-ийг шийдвэрийг харгалзан Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхээр шийдвэрлэв. (Шинжээч: Д.Дулмаа) |
| 5 | “Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын технологи” бакалаврын сургалтын хөтөлбөр | Соёл судлал, геологи чиглэлийн хичээл тусгах, ШУТИС-ийн стандарт шаардлагад нийцүүлэн, хичээл хоорондын уялдаа холбоог эргэн харж сайжруулах. БүХС, ҮТС, МХТС, ГХС-аас албан ёсны санал авах Элсэлт хангалтгүй байгааг анхаарах | Сургалтын хөтөлбөрийг дүрэм, журамд нийцүүлэн сайжруулан дахин хэлэлцүүлэхээр буцаалаа. (Шинжээч: Р.Мядагмаа) |
| 6 | “Хэрэглээний физик” бакалаврын сургалтын хөтөлбөр | Элсэлт хангалтгүй байгааг анхаарах Хөрвөх талыг тооцож сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сайжруулах | ХЕХ-ны томилогдсон гишүүний санал зөвлөмжийг тусган Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхээр дэмжлээ. (Шинжээч: М.Оюунчимэг) |
| 7 | “Статистик” (дотоод) бакалаврын сургалтын хөтөлбөр | МХТС-ийн Өгөгдлийн ухаан хөтөлбөртэй давхардал байгаад анализ хийж арилгах. | ХЕХ-ны гишүүдийн санал зөвлөмжийг тусгаж, сайжруулаад дахин хэлэлцүүлэхээр буцаалаа. (Шинжээч томилж ажиллуулна) |
| 8 | “Бизнес шинжлэл, загварчлал” бакалаврын сургалтын хөтөлбөр | Хичээлийн код алдаатай байгааг засах, статистик, data science, өгөгдлийн талын хичээлүүдийг тусгах | Мэргэжлийн шинжээч томилон ажиллуулах бөгөөд санал зөвлөмжийг тусган сайжруулаад, УМИ-ийн шийдвэрийг харгалзан Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхийг дэмжлээ. (Шинжээч томилж ажиллуулна) |

| | | | |
|----|---|--|--|
| 9 | "Хот бүс нутгийн төлөвлөлт" магистрын сургалтын хөтөлбөр | БуХС, ЭХС, МХТС-тай хамтарн ажиллах, ШУТИС-ийн бодлогоо барих, 3 хэмжээст загвар, ногоон байгууламжийн талаар хичээл тусгах | Мэргэжлийн шинжээч томилон ажиллуулах бөгөөд санал зөвлөмжийг тусган сайжруулаад, УМИ-ийн шийдвэрийг харгалзан Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхийг дэмжлээ. (Шинжээч томилж ажиллуулна) |
| 10 | "Худалдаа" бакалаврын сургалтын хөтөлбөр | Хөтөлбөр нь агуулгын хувьд маркетингийн чиглэл байна. Нийт судлах кредитийг багасгах, өмнөх холбоо хичээл болон хичээл хоорондын уялдааг анхаарах, ОУ-ын худалдаа гэдэг талаас сайжруулалт хийх. СЭЗИС, МУИС-ийн хөтөлбөртэй харьцуулсан судалгаа хийх | ХЕХ-ны гишүүдийн санал зөвлөмжийг тусгаж, сайжруулаад, УМИ-ийн шийдвэрийг харгалзан Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхийг дэмжлээ. (Шинжээч томилж ажиллуулна) |
| 11 | "Орон судлал" сургалтын хөтөлбөрөөр Турк улсын Измир Катип Челеби их сургуультай хамтарсан (1+1,5) хөтөлбөр хэрэгжүүлэх | ШУТИС-ийн стандарт шаардлагад нийцүүлэх, хичээлийн нэршлийг (шашин судлал) анхаарах, Ажлын байрны судалгаа хийх, Ерөнхий орон судлал талаас харж дахин боловсруулах. | ХЕХ-ны гишүүдийн санал зөвлөмжийг тусгаж, сайжруулаад дахин хэлэлцүүлэхээр буцаалаа. (Шинжээч томилж ажиллуулна) |
| 12 | "Бизнес шинжлэл, загварчлал" магистрын сургалтын хөтөлбөр | ШУТИС-ийн стандарт шаардлагад нийцүүлэх | Мэргэжлийн шинжээч томилон ажиллуулах бөгөөд санал зөвлөмжийг тусган сайжруулаад, УМИ-ийн шийдвэрийг харгалзан Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхийг дэмжлээ. (Шинжээч томилж ажиллуулна) |
| 13 | "Энтерпренершип ба инноваци" магистрын сургалтын хөтөлбөр | ШУТИС-ийн стандарт шаардлагад нийцүүлэх, гадаад үг хэллэг дээр анхаарах, элсэгчийн шаардлагыг уян хатан байдлаар шийдвэрлэх | Мэргэжлийн шинжээч томилон ажиллуулах бөгөөд санал зөвлөмжийг тусган сайжруулаад, УМИ-ийн шийдвэрийг харгалзан Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхийг дэмжлээ. (Шинжээч томилж ажиллуулна) |
| 14 | "Инженер геологи, геотехник" бакалаврын сургалтын хөтөлбөр | Инженерийн суурь хичээл тусгах, хичээл хоорондын ерөнхий давхардал байгааг анхаарч арилгах, ОУ-д ижил төстэй хөтөлбөрт тавигдах шаадлагыг судлаж тусгах БАС, ЭХС-ийн санал тусгах | Мэргэжлийн шинжээч томилон ажиллуулах бөгөөд санал зөвлөмжийг тусган сайжруулаад, УМИ-ийн шийдвэрийг харгалзан Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхийг дэмжлээ. (Шинжээч томилж ажиллуулна) |
| 15 | "Хийн инженерчлэл" бакалаврын сургалтын хөтөлбөр | Хичээлийн код, инженер технологийн хөтөлбөрт өөрчлөгдсөн хичээлүүдийг оруулах | Мэргэжлийн шинжээч томилон ажиллуулах бөгөөд санал зөвлөмжийг тусган сайжруулаад, УМИ-ийн |

| | | | |
|----|---|---|---|
| | | Дадлагын хичээлийн кредит нэмэх ЭХС-ийн санал тусгах | шийдвэрийг харгалзан Эрдмийн зөвлөлд хэлэлцүүлэхийг дэмжлээ. (Шинжээч томилж ажиллуулна) |
| 16 | Шинээр нээхээр төлөвлөж байгаа БШУ-ы Сайдын А/160 тушаалд индексгүй сургалтын хөтөлбөрүүдийн асуудал | Бакалаврын хөтөлбөрийг хэт задлахгүй байх, БШУЯ-ны гаргасан судалгаанд менежмент чиглэлээр төгсөгчдийн 40% ажлын байргүй гэсэн үзүүлэлт гарч улс орны бодлого алдагдаад байгаад анхаарах. | БШУЯ-ны Хөтөлбөр /мэргэжил/-ийн нэр индекс шинэчлэн батлах А/160 тушаалд тусгагдаагүй хөтөлбөрийн хувьд БШУЯ-ны бодлого, чиглэлтэй уялдуулж ХЕХ-ноос хавсарга хөтөлбөр, мэргэших чиглэл гаргах шаардлагыг боловсруулж хүргүүлнэ. Үүний дараа энэ асуудлыг дахин хэлэлцүүлж болно. |
| 17 | Хөтөлбөрийн нэр өөрчлөх санал "Хүнсний үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж" хөтөлбөрийн нэрийг "Хүнс үйлдвэрлэлийн мехатроник инженер" | Одоогийн нэршил хэвээр байж хөтөлбөрт шаардлагатай агуулгыг оруулж сайжруулалт хийх эсвэл мехатроник хөтөлбөрт хавсарга хэлбэрээр хэрэгжүүлэх | БШУЯ-аас гарсан бодлого, шийдвэрээ тодорхой хугацаанд тогтвортой барих чиглэлтэй байгаа тул ХЕХ-ны гишүүдийн саналыг тусган хөтөлбөртөө сайжруулалт хийгээд тухайн батлагдсан нэршилээр хэрэгжүүлэх зөвлөмж өгөв. |

Танилцсан:



Н.Эрдэнэхүү
/ХЕХ-ны дарга/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



Г.Ариунтөгс
/ХЕХ-ны гишүүн/